



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 04 сарын 22 өдөр


Дугаар 137

Улаанбаатар хот

Г Т  
Төслийн Удирдах хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газар ба Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газар хоорондын 2011 оны 12 дугаар сард байгуулсан “Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил” МОН/005 төслийг хэрэгжүүлэх буцалтгүй тусlamжийн харилцан ойлголцлын санамж бичгийг үндэслэн ТУШААХ нь:

- “Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил” МОН/005 төслийн Удирдах хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, удирдах хорооны ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
- Удирдах хорооны хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд (Ж.Амарсанаа)-д үүрэг болгосугай.



Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
13.7 тоот тушаалын 1-р хавсралт.


**“ЗҮРХ СУДАСНЫ ТӨВ, ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЦАХИМ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ӨРГӨЖИЛ” MON/005 ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ  
БҮРЭЛДЭХҮҮН**



- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Дэд дарга: Люксембургийн Гадаад Хэргийн Яамны төлөөлөгч
- Нарийн бичгийн дарга: “Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил” MON/005 төслийн үндэсний зохицуулагч
- Гишүүд:  
 ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга  
 ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга  
 ЭМЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга  
 Сангийн яамны Санхүүгийн бодлого, өрийн удирдлагын газрын дарга  
 Люксембургийн хөгжлийн агентлагийн төлөөлөл;  
 НҮБ-ын ХАС-ийн төлөөлөгч;  
 П.Н. Шастины нэрэмжит улсын III төв эмнэлгийн дарга;  
 Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал;

Эрүүл мэндийн сайдын 2013 оны  
13 тоот тушаалын 2-р хавсралт

**“ЗҮРХ СУДАСНЫ ТӨВ, ЭХ НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНД БА ЦАХИМ ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ӨРГӨЖИЛ” МОН/005 ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ  
АЖИЛЛАХ ЖУРАМ**



Нэг: Зорилго

- 1.1. Төслийн үйл ажиллагааг стратегийн нэгдсэн удирдлагаар хангах
- 1.2. Төслийн үйл ажиллагааг үндэсний бодлого, стратегийн хүрээнд уялдуулан зохицуулах

Хоёр: Удирдах хорооны чиг үүрэг

- 2.1. Төслийн баримт бичигт оруулах томоохон өөрчлөлтүүдийг хянан батлах;
- 2.2. Жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн төслийг хянан, баталгаажуулах;
- 2.3. Төслийн жилийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэн дүгнэх;
- 2.4. Төслийн үйл ажиллагааг бусад үндэсний болон олон улсын хөтөлбөр төслүүдтэй уялдуулан зохицуулах;
- 2.5. Бусад яаралтай асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэх;

Гурав. Үйл ажиллагаа

- 3.1. Удирдах хороо нь жилд хоёроос доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал зохион байгуулж болно.
- 3.2. Хорооны дарга, дэд дарга нар эрүүл мэндийн сайд болон бусад холбогдох албан тушаалтан, байгууллагад төслийн хэрэгжилтийн талаар тайлagnана.
- 3.3. Хорооны гишүүдийн 70-аас дээш хувь биечлэн оролцсоноор хурлын ирц бүрдэж хурлыг нээнэ.
- 3.4. Хуралд оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Гишүүд санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.
- 3.5. Нарийн бичгийн дарга нь хорооны хурлын товыг Эрүүл мэндийн дэд сайдтай зөвшилцэж хурал болохоос ажлын 5 хоногийн өмнө зарлах, хурлын тэмдэглэл хөтлөх, хурлын тэмдэглэл, хурлаас гарсан зөвлөмжүүдийг эцэслэн гишүүдэд түгээх үүрэг хүлээнэ.
- 3.6. Хорооны даргын зөвшөөрлөөр бусад олон улсын байгууллага, хандивлагч байгууллагууд болон мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг ажиглагчаар урин оролцуулж болно.